

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 03 дугаар сарын 18-ний өдөр

ТУЗТ 01/2019

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2018 оны санхүүгийн
болон үйл ажиллагааны тайланг
хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлаар шийдвэрлүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэхь заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тус компанийн 2018 оны санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлаар оруулж шийдвэрлүүлсүгэй.
2. Тус компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлаар оруулж шийдвэрлүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б.БАТХҮҮ/

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 03 дугаар сарын 18-ний өдөр

ТУЗТ 02/2019

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ


Компанийн хувьцаа эзэмшигчдийн
2019 оны ээлжит хурал зарлан
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.2, 76.1.3, 60.2, 60.3, 60.4 дахь заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 12.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жуулчны гудамж 44, Арт хаус, 601 тоот, Эс Жи Капитал ҮЦК ХХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Энэ тогтоолын 1-т заасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг 1 дүгээр хавсралтаар, хурлын хөтөлбөр, дэгийг 2 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын танилцаж болох баримт материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудал бүрийн санал авах “Санал авах хуудас”-ыг 4 дүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загварыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар, мэдээг 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөр дахин зарлах өдрийг 15 өдрийн дараа байхаар тогтоож, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсаны дагуу “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журамд заасан хэлбэр, шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Э.Сод-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2019 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын 9-18 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жуулчны гудамж 44-р байр, Арт хаус, 6-р давхарт “Эс Жи Капитал ҮЦК” ХХК-ийн байранд танилцуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Э.Сод-Эрдэнэ/-д даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссыг 2 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулсугай.
8. Хурал зохион байгуулах комиссын
- а. Даргаар: Э. Сод-Эрдэнэ
 - б. Гишүүн: Э. Шагдарсүрэн
- тооллогын комиссын
- с. Даргаар: Э. Шагдарсүрэн
 - д. Гишүүнээр: Э. Сод-Эрдэнэ нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б.БАТХҮҮ/

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн ТУЗТ 02/2019 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт


**“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ЖАГСААЛТ**



1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, батлах;
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайланг хэлэлцэж, батлах;

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн ТУЗТ 02/2019 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

**“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ**



№	Хэлэлцэх асуудал	Шийдвэрийн төсөл	Эхлэх, дуусах хугацаа/цагаар/	Хариуцах эзэн
1.	Хуралд оролцогчдийг бүртгэх		12.00-12.10	Хурал зохион байгуулах комисс
2.	Хурлын ирцийн дүн гаргах, танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	12.10-12.20	Тооллогын комисс
3.	Хурлын даргыг сонгох	Тооллогын комиссын тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	12.20-12.25	Тооллогын комисс
4.	Хурлыг нээж, хурлын дарга үг хэлнэ.		12.25-12.30	Хурлын дарга
5.	Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	12.30-12.40	ТУЗ-ын дарга
6.	Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэх тухай;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	12.40-12.50	ТУЗ-ын дарга
9.	Асуулт, хариулт		12.50-13.00	Хурлын дарга
10.	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал асуултын хуудсаар санал хураах;	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	13.00-13.30	Тооллогын комисс
11.	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүд гарах;	Тооллогын комиссын тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	13.30-13.40	Тооллогын комисс
12.	Хурлыг хаах		13.40-13.50	Хурлын дарга

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн ТУЗТ 02/2019 тоот тогтоолын 3 дугаар хавсралт


**“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**



1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн хуулбар;
2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрийн төсөл;
3. Компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан;
4. Компанийн 2018 оны санхүүгийн тайланг батлах тухай Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрийн төсөл;

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн ТУЗТ 02/2019 тоот тогтоолын 4 дүгээр хавсралт

**“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**



Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /брокерийн компани/

Брокерийн овогнэр

Санал өгсөн огноо: 2019 оны сар өдөр

Хувьцааны төрөл:/энгийн, эсвэл давуу эрхийн/.....

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн өглөөний 12 цаг 00 минутад Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жуулчны гудамж 44, Арт хаус, 601 тоот, Эс Жи Капитал ҮЦК ХХК-ийн байранд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг зөвшөөрч батлахыг			
2	Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн дүгнэлтийг зөвшөөрч батлахыг			

Хувьцаа эзэмшигчгарын үсэг

Брокергарын үсэг

/тэмдэг/

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүй тооцон тоолсон:..... гарын үсэг

Хүчингүйд тооцсон бол шалтгаан нь:.....

Тооллогын комиссын дарга:..... гарын үсэг

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ын ердийн болон хараат гишүүдийг сонгохдоо кумулятив аргыг хэрэглэнэ.
2. Санал авах хуудсыг зуучлагч брокер дилерийн компани нь “Саналын хуудас”-ыг бөглүүлэхээс өмнө тамга даран баталгаажуулан хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Хэрэв санал өгөх эрхээ өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөний хүндээ итгэмжлэл бичиж өгч нотириатаар баталгаажуулсан байна.
4. Засварласан, балласан болон залруулгатай “Саналын хуудас” хүчингүйд тооцогдоно.

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн ТУЗТ 02/2019 тоот тогтоолын 5 дугаар хавсралт



Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загвар

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4-р сарын 28-ны өдрийн 12.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Жуулчны гудамж 44, Арт хаус, 601 тоот, Эс Жи Капитал ҮЦК ХХК-ийн байранд болно.

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр: 2019-04-09

Хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайланг хэлэлцэх;

Хурлын материалтай 2019 оны 03-р сарын 19-ний өдрөөс 04-р сарын 27-ны хооронд ажлын өдрүүдэд 9-18 цагийн хооронд УБ, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус, 6-р давхар, “Эс Жи Капитал ҮЦК” ХХК-ийн байранд ирж танилцах боломжтой.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс Э. Сод-Эрдэнэ, Э. Шагдарсүрэн

Утас: 99922517

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС